



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№106 /550/

2023.07.05

Цаг үе, үйл явдал

ГЕНЕРАЛ УЧИКУРА ХИРОАК-Г ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Агаарын цэргийн командлагч, генерал Учикура Хироакиг хүлээн авч уулзлаа.

Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр генерал Х.Учикураг Монгол Улсад тавтай айлчлахыг хүсэн, Японы Агаарын цэргийн

командлагч анх удаа Монгол Улсад айлчилж буйг тэмдэглээд, хоёр орны Агаарын цэргийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжиж буйд баяртай байгаагаа илэрхийлэв.

Генерал Х.Учикура Батлан хамгаалахын сайдыг өөрийн биеэр хүлээн авч уулзаж буйд талархал илэрхийлж, цаашид хоёр орны Агаарын цэргийн харилцааг хөгжүүлэхэд анхааран ажиллахаа мэдэгдэв.

ХУРДАН МОРИНЫ САЛБАР ХОРОО ЭЭЛЖИТ ХУРЛАА ХИЙЛЭЭ



Тулгар төрийн 2232, Их Монгол Улсын 817, Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Үндэсний их баяр наадмын Хурдан морины салбар хороо ээлжит хурлаа хийлээ.

Энэ жилийн баяр наадмын онцлог нь 2023 оныг аялал жуулчлалыг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан хурдан морины уралдааныг жуулчдад үзүүлж, сонирхуулах боломжийг нэмэгдүүлэх талаар тодорхой саналуудыг тусгаж ажиллах нь чухал гэдгийг тус салбар хорооны Нарийн бичгийн дарга, НЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Г.Ялалт хурлын эхэнд онцлов.

Мөн Үндэсний их баяр наадмын тухай хууль, Хурдан морины уралдааны дүрмийг чанд баримталж, наадамчин олны тав тухыг хангах

хүрээнд ажлын хэсгүүд уялдаа холбоотой ажиллах, ойрын хугацаанд Хүй долоон худагт хотхон босгох, ариун цэврийн байгууламжуудын асуудлыг бүрэн шийдэх зэргийг үүрэг болгов.

Энэ үеэр салбар хорооны бүрэлдэхүүн тус тусын ажлын явцыг тайлагнаж, холбогдох санал зөвлөмжүүдээ уламжилсан юм.

Түүнчлэн Хурдан морины салбар хорооны орлогч дарга бэлтгэл бригадын генерал Б.Ганбаатар төр, засгаас даалгасан энэ ажлын ард амжилттай гарахын тулд хүн бүрийн сахилга бат, үүрэг оролцоо чухал хэмээгээд бүртгэл, хэмжилт, зохион байгуулалтын талаар зарим албан тушаалтанд чиглэл өглөө.

Хурлын дараа салбар хорооны удирдлагууд хурдан морины уралдаан болох газар оронд ажилласан юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 16	🌧️ 11

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	🌧️ 22

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,432	3,447
EUR 🇪🇺	3,740	3,750
CNY 🇨🇳	477	481
RUB 🇷🇺	38	38,80
JPY 🇯🇵	24	24,15
KRW 🇰🇷	2.62	2.64

ЗУРХАЙ



2023.07.05 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 17

ЗУНЫ ДУНД ШАР МОРЬ САР НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХ ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:

Өнгө зүс доройтно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.00-20.54

Барилдлага:

Идэр

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Төрөн түгэхүй

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, хувцас хийх, гэр орон барих, сан нуун дарахад сайн. Зүүн нүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүд татвал эд олдох, зүүн чих хангинавал аймшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэмцэл болох, хэрээ дуугарвал зочид ирэх, тагнай загатнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хөл татвал үзэсгэлэн болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 663,696,760

Эдгэрсэн

Нийт: 650,524,905

Нас барсан

Нийт: 6,897,872

Цахим шууданд

ОЮУТАН ЦЭРГҮҮД БУУДЛАГЫН ДАСГАЛ БОЛОВСРУУЛЛАА



ҮБХИС-ийн Шархадны хээрийн сургалтын төвд "Оюутан цэрэг" сургалтад хамрагдаж байгаа дайчид сургалтын төлөвлөгөөний дагуу сургуулийн буудлагын анхны дасгал (БАД-1) боловсрууллаа. Энэ жилийн хувьд Оюутан цэрэг сургалтад хамрагдаж байгаа дайчдаас II-р ротын III-р салааны байлдагч Г. Тэмүүжин Буудлагын улсын аваргын "Junior" төрөлд гуравдугаар байрын шагналтай. IV-р ротын I-р салааны байлдагч Т. Мөнгөн-Очир нь Практик буудлагын Дэд мастер цолтой бөгөөд гар бууны ОУ-ын тэмцээнд хоёр удаа оролцож IV болон V дугаар байр эзэлж байсан. Мөн Улсын аваргын гурван алт, нэг мөнгө, хоёр хүрэл, Прайм клубийн аварга шалгаруулах тэмцээний таван алт, таван мөнгө, дөрвөн хүрэл, 5.11 чалленж тэмцээний хоёр алт, нэг хүрэл, Mongolian warrior тэмцээний хоёр алт, нэг мөнгөн медаль хүртэж байсан онцлогтой байна.

НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА



Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2023-2024 онд үүрэг гүйцэтгэх штабын ажилтан (офицер), цэргийн мэргэжилтний (цэргийн ажиглагч, холбогч офицер) сонгон шалгаруулалтыг 2023 оны 07 дугаар сарын 31-нээс 08 дугаар сарын 04-ний өдрүүдэд зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид 2021 онд батлагдсан "ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ"-тай танилцаж, НҮБ-ын штабын ажилтан, цэргийн мэргэжилтэнд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын Энхийг дэмжих, цэргийн хамтын ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн дотор ирүүлнэ. Үүнд:

1. Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;
2. Ажил байдлын тодорхойлолт;
3. Жолооны үнэмлэхийн хуулбар;
4. Гадаад паспортын хуулбар;
5. Цэргийн ажиглагч, штабын офицерын сургалт, дамжаа дүүргэсэн сертификатын хуулбар;
6. Сүүлийн 3 сарын дотор авхуулсан 4х6 хэмжээтэй цээж зураг 2 хувь;
7. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт
8. Товч судалгаа (доорх хүснэгтийн дагуу бөглөх);

Ангил	Албан тушаал	Цол	Өвөг нэр	Нас, хүйс	Боловсрол, цэргийн мэргэжил, дамжаа төгссөн байдал	Ангил, байгууллагад ажилласан байдал	Одоогийн албан тушаалд томилогдсон огноо	Эдгээр үүрэг гүйцэтгэсэн байдал	Ангил хэргийн түвшин тогтоох шалгалтын оноо (Хамтын сүүлд өгсөн IELTS, TOEFL, IELTS)
-------	--------------	-----	----------	-----------	--	--------------------------------------	--	---------------------------------	--

Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг ЗХЖШ-ын Энхийг дэмжих, цэргийн хамтын ажиллагааны хэлтэс psod@mil.gov.mn цахим шуудангаар болон /3679, 99732447/-тай холбогдож тодруулна уу. "ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ"-тай ЗХЖШ-ын цахим хуудасны эрх зүйн булан буюу <https://gsmaf.gov.mn/gsmf/cst/60> холбоосоор орж танилцана уу.

ЗХЖШ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ, ЦЭРГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

ОЮУТАН ЦЭРГҮҮД 10 КМ-ИЙН ЯВГАН МАРШ ҮЙЛДЛЭЭ



ҮБХИС-ийн Шархад дахь төлөвлөн зохион байгууллага. Тус хээрийн сургалтын төвд "Оюутан цэрэг" сургалтад хамрагдаж байгаа дайчдыг бие бялдгар, тэсвэр хатуужил, сэтгэл зүйн байдлыг дээшлүүлэх зорилгоор 10 км-ийн явган маршийг сургалтын төлөвлөгөөний дагуу төлөвлөн зохион байгуулна. Тус хээрийн сургалтын төвд "Оюутан цэрэг" сургалтад хамрагдаж байгаа дайчдыг бие бялдгар, тэсвэр хатуужил, сэтгэл зүйн байдлыг дээшлүүлэх зорилгоор 10 км-ийн явган маршийг сургалтын төлөвлөгөөний дагуу төлөвлөн зохион байгуулна. Тус хээрийн сургалтын төвд "Оюутан цэрэг" сургалтад хамрагдаж байгаа дайчдыг бие бялдгар, тэсвэр хатуужил, сэтгэл зүйн байдлыг дээшлүүлэх зорилгоор 10 км-ийн явган маршийг сургалтын төлөвлөгөөний дагуу төлөвлөн зохион байгуулна.



Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)

БХЭШХ 45 ЖИЛИЙН ОЙДОО БЭЛТГЭЖ БАЙНА



засаг, салбарын удирдлагаас үргэлж анхааран ажиллаж ирсэн билээ.

Хүрээлэн нь шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх төр, засгийн бодлого, үйл ажиллагаанд цэргийн шинжлэх ухааны судалгаа хөгжүүлэлтийн чиглэлээр ихээхэн хувь нэмэр оруулсаар ирсэн.

Тиймээс тус хүрээлэнгийн 45 жилийн хугацаанд гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг сурталчлах, улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын бодлогыг боловсруулах, тодорхойлоход оруулсан хувь нэмрийг үнэлэн, дүгнэх, цаашид судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлэн хөгжүүлэх хэтийн төлөвийг тодорхойлох зорилгоор "Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 45 жилийн ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн захирлаар батлуулан хэрэгжүүлж эхлээд байна.

Ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд нийт 21 томоохон арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Тухайлбал, БХЭШХ-ийн "Брэнд ном", "БХЭШХ-45" түүхийн зурагт ном, богино хэмжээний баримтат кино хийхээр төлөвлөсөн бол хүрээлэнгийн үйл ажиллагааг "Соёмбо" сонин, "Дуулга" студи бусад хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй хамтран сурталчлах ажлыг төлөвлөжээ. Түүнчлэн ахмад залуу үеийн холбоог сайжруулах, туршлага, солилцох уулзалт, ярилцлага, төвийн өдөрлөг зохион байгуулах, залуу судлаачдыг хөгжүүлэх сургалтад хамруулах зэрэг томоохон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр зорьжээ.

БҮЖИГЧДИЙН АНХНЫ ХӨШӨӨ СҮНДЭРЛЭН БОСЛОО



"Монгол цэргийн бүжигчдийн алдар" хөшөө уран барималч Б.Нямдоржийн оюун ухаанаар амилжээ. Тэрээр хөшөөний эх загварыг гаргах гэж Цэргийн чуулгын бүжигчдийн "Аягаг" бүжгээс 200 гаруй тавилт бүхий зураг авсанаас энэхүү загварыг гаргасан байна.

Х.Ёндон агсантай хамтран уран бүтээл туурвиж явсан УГЗ Ш.Гунаажав "Анд маань урлагийн төлөө бүхнээ зориулсан. Ганцхан жишээ дурдахад 300 бүжигчин цуглуулж тоглолт хийж байсан. "Дайчин алдар" чуулгыг байгуулж эх орондоо төдийгүй хилийн чанадад Москвад хүртэл айлчлан тоглолт хийсэн хүн дээ" хэмээн өгүүлсэн. Цэргийн урлагийн "Хаан бүжиг" гэж хэлэх үндэстэй "Цэргийн чуулбар" бүжгийн хөгжмийг зохиосон нэрт хөгжмийн зохиолч Ш.Гунаажав гуай залуудаа бүжигчин явжээ.

Хөшөөний нүүрэн хэсэгт Чөлөөлөх дайны түгшүүрт өдрүүдэд Цэргийн ансамблийн уран бүтээлчдийн Долоннуур хүртэл аялан тоглосон замын зургийг товойлгон сийлжээ.

Хөшөөний нээлтийн туузыг хайчилсны дараа Зэвсэгт хүчний Соёлын төв өргөөний "Соёмбо" танхимд дэд хурандаа Х.Ёндонгийн амьдрал, үйл ажиллагааны тухай өгүүлсэн баримтат кино, номын нээлт боллоо.

Х.Ёндонгийн мэндэлсний 100 жилийн ойн хүрээнд түүний үр хүүхдүүд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Соёлын төвийг шинэчлэн засварлаж, тохижуулан түүний нэрэмжит "Монгол бүжгийн гайхамшиг" бүжгийн уралдааныг 2017 оноос эхлэн хоёр жил тутамд зохион байгуулж ирсэн гээд цөөнгүй ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Цэргийн үе үеийн бүжигчдийн "Дурсамж" бүжгийн хэсэгчилсэн үзүүлбэр олны халуун талархлыг хүлээж байлаа. Монгол бүжгийн "Гэрэгэ" холбооны тэргүүн, Монгол Улсын Гавьяат жүжигчин Л.Ганчимэг "Ёндон багш хэзээ ч би гэж ярьдаггүй, бид тэгж явсан гэдэг сэн. Тэрээр бүжгийн шинэ дэглэлтийн санаагаа тулгаж байгаагүй, өөрсдийн бодлоор хөгжүүлээрийг гэдэг байлаа" хэмээн дурсан яриад аав, ээжээрээ дамжуулан цэргийн бүжигчдийн гавьяаг мөнхлөх эрхэм үйлсийг санаачилсан Х.Ёндон агсны охин Ё.Өнөрбаярт Холбооныхоо Хүндэт өргөмжлөлийг гардууллаа.

Хөшөө босгох санаачилгыг халуун дотно хүлээн авсан ЦДБЭЧ-ын удирдлага, хамт олон, саналыг дэмжиж зөвшөөрөл өгсөн БХЯ-ны удирдлагад ахмад дайчин, бүжигчин, дипломат, дэд хурандаа Х.Ёндонгийн үр хүүхдүүд гүн талархал илэрхийлж байна.

Офицеруудын ордны өмнөх ногоон цэцэрлэгт Монголын цэргийн бүжигчдийн дурсгалын хөшөө сүндэрлэн бослоо.

1945 оны Чөлөөлөх дайнд Цэргийн дуу танцны ансамблийг удирдаж, фронтод мордож Монгол, Зөвлөлтийн дайчид, чөлөөлөгдсөн Өвөрмонголын ард иргэдэд соёл урлагаар үйлчилж явсан ахмад дайчин, бүжигчин, дипломат дэд хурандаа Хорлоогийн Ёндон, түүний гэргий бүжигчин Цэрэнпилийн Цэнд агсны дурсгалд зориулж үр хүүхдүүдийн сэтгэлийн хандив, санаачилгаар энэхүү гэрэлт хөшөө сүндэрлэжээ.

Түүний охин Ё.Өнөрбаяр "Аавын минь мэндэлсний 100 жилийн ойг тохиолдуулан босгож буй энэ хөшөө үе үеийн цэргийн бүжигчдийн суу алдрыг мөнхлөлөө. Аав, ээж хоёр маань хоёулаа цэргийн бүжигчид төдийгүй Зөвлөлтийн алдарт бүжигчин Игорь Моисеевоор бүжиг заалгаж, цэргийн бүжгийн тулгын чулууг тавьсан түүхтэй юм билээ. Энэ уламжлалыг ахмад, дунд, залуу үеийн бүжигчид өртөөлөн үргэлжлүүлж, нэр төртэй хөгжүүлсээр ирсэн гавьяаг мөнхжүүлэх зорилго тавьсан минь биеллээ оллоо" гэлээ.